

ДСЦТС ХК

Компанийн засаглалын үнэлгээний асуулга

Кодексийн хэрэгжилтийг "Хэрэгжүүл, эсвэл тайлбарла" гэсэн зарчмын дагуу тайлагнах ба кодексийн зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, эсхүл авч байгаа, хэрэв төлөвлөж буй бол хугацаатайгаар нь тайлбар хэсэгт тусгана.

НЭГ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна

№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Оноо	Хувь
1	1.1. Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.	Биелсэн	ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, аудитын хорооны журам, ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хорооны журам, цалин урамшуулалын хорооны журам, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын журам зэрэг үйл ажиллагааны журамыг батлан ажиллаж байна.		
2	1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримттай байна.	Биелсэн	6 зүйлээс бүрдэх нэх дэвшүүлэх хорооны журамыг мөрдөн ажиллаж байгаа болно.		
3	1.3. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, цахим хуудсандаа байршуулна.	Биелсэн	Холбогдох мэдээллийг компанийн цахим хуудсанд байршуулсан болно		
4	1.4. Компани нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримттай байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэрт байдал зэргийг тусгана.	Биелсэн	Бодлогын баримт бичгийн дагуу ТУЗ-ийн 9 гишүүний 3/1-ээс доошгүй гишүүд буюу С.Нэргүй, Э.Долгорсүрэн, Т.Энхмэнд гэсэн гурван эмэгтэй ТУЗ-ийн гишүүн 2022 онд томилогдон ажиллаж байгаа болно.		
5	1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүрэгээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар,	Биелсэн	ТУЗ-ийн гишүүд нь компанийн засаглалын сургалтад суусан гэрчилгээг авсан бөгөөд энэ жил улиран ажиллаж байгаа болно. 2022 оны		

	<i>мэдлэг, мэдээллийг олгох, тэдгээрийг шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.</i>		шинэ ТУЗ-ийн эхний хуралд ТУЗ-ийн гишүүдийн гарын авлагыг олгосон болно.		
6	<i>1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.</i>	Биелсэн	ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга нь Компанийн засаглалын гэрчилгээ авсан, хуульчийн эрхийн гэрчилгээтэй эрх зүйч мэргэжилтэй ажилтан бөгөөд хуулийн шаардлагыг бүрэн ойлгож байгаа болно.		
ДҮН					
ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ					
ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ					
7	<i>2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.</i>	биелсэн	ТУЗ-ийн дарга Ц.Баярбаатар, Аудитын хорооны дарга Л.Балган, Г.Бэхбат нар нь 2022-2023 онд хараат бус гишүүдээр томилогдон ажиллаж байна. Гишүүн Н.Эрдэнэбат, Б.Эрдэнэбилэг нар нь мөн хараат бус гишүүний шаардлагыг хангаж байгаа боломж ердийн гишүүдээр томилогдон ажиллаж байна. Компийн 100 хувийн хувьцааг төлөөлж буй хоёр хувьцаа эзэмшигч ТУЗ-ийн бүрэлдэхүүнд багтсан.		
8	<i>2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.</i>	биелсэн	ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллаганы журам болон аудитын бодлогын бичиг баримттай болно. Түүнчлэн аудитын хорооны дарга Л.балган нь ТУЗ-ийн даргын албан тушаалыг хашдаггүй болно.		
9	<i>2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.</i>	Биелсэн	ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшуулалын хороо нь цалин урамшууллалын үйл ажиллагааны журам, бодлогын баримт бичигтэй болно. Цалин урамшуулалын хороон дарга Г.Бэхбат нь ТУЗ-ийн дарга бус, хараат бус гишүүн болно.		

10	2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.	Биелсэн.	ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь цалин урамшууллалын үйл ажиллагааны журам, бодлогын баримт бичигтэй болно. Цалин урамшуулалын хороон дарга Г.Бэхбат нь ТУЗ-ийн дарга бус, хараат бус гишүүн болно.		
11	2.5. ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршилага бүхий бүрэлдэхүүнтэй байна.	Биелсэн	ТУЗ-ийн 9 гишүүний дараах гишүүдээс Ц.Баярбаатар, Н.Эрдэнбат, Б.Эрдэнэбилэг С.Нэргүй нар эрчим хүчний салбарт инжиенер болон удирдах түвшний ажил хийж байсан буюу байгаа туршлагнтай албан хаагчид болно. Аудитын хороон дарга мэргэшсэн нягтлан бодогч Л.Балган нь эрчим хүчний салбарт санхүү, татвар, нягтлан болох чиглэлээр олон жил ажилласан туршлагтай боловсон хүчин болно. ТУЗ-ийн аудитын хорооны гишүүн Э.Долгорсүрэн нь мэргэшсэн нягтлан бодогч мэргэшилтэй болно.		
ДҮН					
ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ					
ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана					
12	3.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Биелсэн	ТУЗ нь мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталсан бөгөөд хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байгаа болно.		
13	3.2. ТУЗ нь энэхүү кодексст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.	Биелсэн	Холбогдох мэдээллийг цахим хуудсанд байршуулсан болно.		
14	3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн	Биелсэн	Санхүүгийн бус тайланд холбогдох мэдээлийг тусгасан болно.		

	эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.				
ДҮН					
ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО					
ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана					
15	4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Биелсэн	Адитын хорооны үйл ажиллагааны журамыг мөрдөн ажиллаж байгаа бөгөөд хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байгаа болно.		
16	4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.	Биелсэн	Хөндлөнгийн аудитор нь аудиттой холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгөн ажиллаж байгаа болно.		
17	4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар олон нийтэд тухай бүр мэдээлнэ.		Холбогдох мэдээллийг олон нийэд болон хувьцаа эзэмшигчдэд тухайбүр мэдээлж байгаа болно.		
ДҮН					
ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА					
ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина					
18	5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	биелсэн	Компани эрсдлийн зааварыг үлгэрчилсэн загварын дагуу мөрдлөн ажиллаж байгаа болно. Аудитын хороо нь байгууллагын эрсдлийн удирдлага хэрэгжүүлж, түүний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байгаа болно.		
19	5.2. ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны	Биелсэн	Эрдлийн удирдлагын хорооны чиг үүргийг ахудитын хороо хэрэгжүүлж байгаа бөгөөд хараахан хуралдаагүй байгаа болно.		

	<i>хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.</i>				
20	<i>5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.</i>	Биелсэн	Холбогдох мэдээллийг олон нийтэд мэдээлж байгууллагын фэйс бүүк болон цахим хаягт байршуулсан болно.		
21	<i>5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.</i>	Биелсэн	Компанийн ТУЗ-ийн зүгээс комплайнсийн хяналтын заавар болон бүтэцтэй бөгөөд харуут бус байдалд ТУЗ хяналт тавин ажиллаж байгаа болно.		
ДҮН					
ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ					
Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна					
22	<i>6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.</i>	Биелсэн	ТУЗ-ийн төсөв, цалин урамшуулалын хэмжээ, олгох заавар, давтамжийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн баталсан болно.		
23	<i>6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана.</i>	Биелсэн.	Компанийн цалин урамшуулалын хэмжээг Эрчим хүчний зохицуулах хороо болон Эрчим хүчний яам хянан танилцаж, санал шүүмж өгч ажилладаг болно. Цалин урамшаалалын бодлогын баримтыг мөрдөн ажиллаж байгаа болно.		
24	<i>6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.</i>				
ДҮН					
ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ					
Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ					
25	<i>7.1. Компани нь ТУЗ-өөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах</i>	Биелсэн	Компани нь холбогдох бичиг баримтыг батлан, мөрдөж байгаа болно.		

	<i>байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.</i>				
26	<i>7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.</i>	Биелсэн	Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд холбогдох мэдээллийг тусгахаар төлөвлөн ажиллаж байгаа болно		
27	<i>7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.</i>	Биелсэн	Компанийн цахим хуудас болон фэйсбүүк пэйжийг ажиллуулж байгаа болно.		
28	<i>7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.</i>	Биелсэн	Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөг мөрдөн ажиллаж байгаа болно.		

ДҮН

НАЙМ. КОМПАНИЙН СОЁЛ

ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно

29	<i>8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</i>				
30	<i>8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үлээгчийн” тогтолцоотой байна.</i>		Шүгэл үлээгчийн тогтолцоог мөрдөн ажиллаж байгаа болно.		
31	<i>8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.</i>	Биелсэн	Ёс зүйн дүрмийг мөрдөн ажиллаж байгаа болно.		

ДҮН

ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ

Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бөлөлцөөгөөр бүрэн хангана

32	9.1. Компани оролцогч талуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа тухай бүр хүргэнэ.	Биелсэн	Холбогдох мэдээллийг цахим хуудсаар тухай бүр хүргэн ажиллаж байгаа болно		
33	9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба тэдэнтэй харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.	Биелсэн	Компани хөрөнгө оруулагчтай харилцах хөтөлбөрийг баталсан бөгөөд тэдэнтэй харилцах цахим сувгийг хөгжүүлж байгаа болно.		
34	9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.		Компани хувьцаа эзэмшигчдийн хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцлийг бүрдүүлэн ажиллаж байгаа болно.		
35	9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.		Компанийн үйл ажиллагааны чиглэл, өчлөгчдийн бүтцийн талаар хувьцаа эзэмшигчил санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь анхааран ажилладаг болно.		
36	9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхолын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.		Компани нь сонирхолын зөрчилтэй хэцэл хийх журтай бөгөөд хуульд заасын дагуу сонирхолын зөрчилтэй хэлцлийг ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн батлах журамтай болно.		
ДҮН					
НЭГДСЭН ДҮН					